



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 6

Улаанбаатар
хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Концессын тухай хуулийн 24.2.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 364 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших “Болд Төмөр Ерөө Гол” ХХК-ийн төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих” төсөл болон “Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих” төслийн концессын “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулсан нэмэлт гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлахыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төслүүдэд зориулан концесс эзэмшигчид улсын төсвөөс олгосон хөрөнгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай.

4. Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 5 дахь заалтын “Концессын төрөл” гэсэн баганын “Барих-шилжүүлэх” гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Г.ЗАНДАНШАТАР